

## МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 2 дүгээр  
сарын 18 өдөр

Дугаар 53/45

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 16.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь :

Нэг. Спортын их наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг нэгдүгээр, Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадам зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Улсын хэмжээнд мөрдөгдөх биеийн тамир, спортын холбогдолтой дүрэм, журам заавруудыг энэ тушаалтай нийцүүлэн шинэчлэн боловсруулахыг Биеийн тамир, спортын газар /Ч.Наранбаатар /-д үүрэг болгосугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Бүжин/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар/Н.Түмэндэмбэрэл/, Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар/ Б.Батжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан 2002 оны 24/19 тоот тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД С.ЛАМБАА

САНГИЙН САЙД  
С.БАЯРЦОГТ

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын  
хамтарсан 2009 оны 53/45 тоот тушаалын  
нэгдүгээр хавсралт

## **СПОРТЫН ИХ НААДАМ, УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл:**

1.1. Монгол Улсын Засгийн газар, Биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр үндэсний хэмжээнд явуулах спортын их наадам, Улсын аварга шалгаруулах бүсийн болон шигшээ тэмцээнийг /цаашид тэмцээн гэх/ зохион байгуулах, хамрагдагчдыг бэлтгэн оролцуулах, санхүүжүүлэх харилцааг холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд энэхүү журмаар зохицуулна.

1.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмцээнийг зохион байгуулах, санхүүжүүлэх харилцааг энэхүү журмаар нэгэн адил баримтлана.

### **Хоёр. Тэмцээний зохион байгуулалт:**

2.1. Тэмцээнийг аж ахуйн нэгж, байгууллага; сум, хороо; дүүрэг, аймаг; нийслэл, бүс; улсын /шигшээ/ гэсэн шатлалтайгаар зохион байгуулна.

2.2. Тэмцээн зохион байгуулах спортын төрлийн тоо, ангилал, зай, жинг “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн 9.3.3 заасан дагуу Биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

2.3. Тэмцээнийг зохион байгуулах ажлыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид захиалагч гэх/ тухайн төрлийн спортын холбоо, бусад байгууллага, иргэн/цаашид гүйцэтгэгч гэх/-тэй гэрээ байгуулах замаар гүйцэтгүүлж болно.

2.4. Гүйцэтгэгч нь тэмцээнийг тухайн нутаг дэвсгэрийн Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.5. Энэ журмаар зохицуулагдахгүй бусад шатны тэмцээнийг тухайн шатны Биеийн тамир спортын асуудал эрхэлсэн байгууллага, бусад дэмжигчид хамтран зохион байгуулна.

2.6. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тэмцээн зохион байгуулах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.7. Гэрээний биелэлтэнд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

2.8. Тухайн спортын холбоо тэмцээний заавар, төсвийн төслийг Биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тэмцээний өмнөх жилийн эхний улиралд багтаан ирүүлэх ба Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ирүүлсэн төслийг хянан нэгтгэж дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэлд тусгана.

2.9. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тэмцээний нэгдсэн зааврыг боловсруулан баталж, төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахаас өмнө оролцох байгууллагуудад хүргэнэ.

2.10. Спортын их наадмын хөтөлбөрт багтсан төрлүүдийн тухайн насны ангиллаар Улсын аварга шалгаруулах тэмцээнийг тухайн жилд давхардуулан явуулахгүй.

2.11. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Бүсийн болон шигшээ тэмцээнийг Нийслэлээс бусад газарт жил дараалан явуулахгүй.

2.12. Бүсийн бүрэлдэхүүнийг тогтоохдоо спортын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нөхцлийг харгалзана.

2.13. Тэмцээнийг нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагын хүсэлтийг харгалзан тухайн орон нутагт зохион байгуулж болно.

2.14. Нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагаас хүсэлт гаргахдаа тэмцээний зорилго, ажлын төлөвлөгөө, төсвийн тооцоог хавсарган тэмцээний өмнөх жилийн эхний улиралд багтаан Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

2.15. Тэмцээн зохион байгуулах хүсэлтийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.16. Тэмцээнд амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагч, байгууллагуудад олгох цом, медаль, шагналын загварыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлах ба медалийн нүүрэн талд спортын төрлийн онцлог, тухайн оны улсын аварга/спортын их наадам/гэдгийг илтгэсэн дүрс, бичиглэл, ар талдаа Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын логог байршуулан цутгаж хэвлэсэн байна.

2.17. Гүйцэтгэгч тал тэмцээний тайланг, маягт, зааврын дагуу үнэн зөв гарган тэмцээн дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан захиалагчид хүлээлгэж өгнө.

### **Гурав. Тэмцээнд бэлтгэх, оролцуулах:**

3.1. Тэмцээнд бэлтгэх, оролцох тамирчид, арга зүйч, багш, дасгалжуулагч, шүүгчдийг харъяалах шатны Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хүсэлтийг үндэслэн үндсэн ажил, хичээлээс нь дор дурдсан хугацаагаар ажлын хоногоор чөлөөлнө. Үүнд:

3.1.1. Сум, аймаг, дүүрэг, нийслэлийн аварга шалгаруулах болон бүсийн тэмцээнд оролцоход 10-аас доошгүй хоног;

3.1.2. Шигшээ тэмцээнд оролцоход 14- өөс доошгүй хоног;

3.1.3. Тэмцээнд ажиллах шүүгчийг тэмцээний өмнөх болон тэмцээний өдрүүдэд.

3.2. Ажлаас чөлөөлөгдсөн хугацааны цалинг дараах байдлаар өмчийн хэлбэр харгалзахгүйгээр үндсэн байгууллагаас нь олгоно.

3.2.1. Хийснээр буюу цагаар цалин олгодог бол сүүлийн гурван сарын цалингийн дунджаар;

3.2.2. Тогтмол цалин олгодог бол чөлөөлөгдсөн хугацаанд ногдох хэсгийг;

3.3. Бүх шатны тэмцээнд оролцогчдоос тэмцээн зохион байгуулагчдын зүгээс төлбөр хураамж авахыг хориглоно.

### **Дөрөв. Тэмцээний санхүүжилт:**

4.1. Тэмцээний шагнал, үйл ажиллагааны зардлыг “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн 20.3 дахь заалтыг баримтлан санхүүжүүлнэ.

4.2. Тэмцээний үйл ажиллагааны зардалд заал, узель, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түрээслэх, худалдан авах, шүүгчийн болон тээврийн хөлс, зар, сурталчилгаа, эмнэлгийн үйлчилгээ, тэмцээн зохион байгуулалтын ажлын хөлс бусад зардалууд хамаарна.

4.3. Тэмцээнд оролцогчдын томилолт, унааны зардлыг оролцуулагч байгууллага, шүүгч, зохион байгуулагчдын зардлыг томилсон байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсын Сангийн сайдын “Албан томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” 2006 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 64 тоот тушаалаар тооцож олгоно.

4.4. Тэмцээнийг шүүсэн шүүгчдэд тэдний зэрэг цолтой уялдуулан ажилласан өдөр тутамд дор зааснаас доошгүй хөлсийг олгоно.

4.4.1. Олон улсын шүүгч 20 000 төгрөг

4.4.2. Улсын шүүгч 15 000 төгрөг

4.4.3. 1-р зэргийн шүүгч 10 000 төгрөг

4.4.4. 2-р зэргийн шүүгч 8000 төгрөг

4.4.5. 3-р зэргийн шүүгч 6000 төгрөг

4.4.6. Туслах шүүгч 5000 төгрөг

4.4.7. Тэмцээнд ажилласан их эмч, улсын засуулыг улсын шүүгчтэй, бага эмч, засуулыг 1-р зэргийн шүүгчтэй адилтган үзнэ.

4.5. Тэмцээнийг гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ивээн тэтгэлэг, хандив, дэмжлэг, тусламжаар зохион байгуулж болно.

4.6. Шигшээ тэмцээний зай, жин түүнтэй адилтгах ангилал тус бүрээр эхний гурван байрт шалгарсан тамирчид, багийн дасгалжуулагчдад өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, спортын их наадмын нэгдсэн дүнгээр эхний байруудад шалгарсан байгууллагад цом, өргөмжлөл, мөнгөн шагналыг тус тус олгоно.

4.7. Энэ журмын 2.2-т заасан шалгаруулалтаар авсан үнэлгээний ангилалтай дүйцүүлэн үйл ажиллагааны болон шагналын зардалыг спортын төрөл тус бүрт дараах байдлаар ялгавартайгаар тогтоон олгоно.

Д/д	Үнэлгээний ангилал / Оноо /	Насанд хүрэгчид /оюутан, залуучууд/		Өсвөр үе	
		Үйл ажиллагаа	Шагнал	Үйл ажиллагаа	Шагнал
1.	Маш сайн /90-100/	+	+	+	+
2.	Сайн /81-89/	+	+	+	
3.	Хангалттай /70-79/	+	+		

4.	Үүрэгтэй /60-69/	+			
----	------------------	---	--	--	--

4.8. Энэхүү журамд заагдсанаас бусад тэмцээний санхүүжилтийг уг тэмцээнийг санаачлан зохион байгуулагч тал хариуцна.

4.9. Тамирчин тэмцээний зааварт заасан насны хязгаарлалтыг зөрчсөн бол тухайн тамирчны тэмцээнд үзүүлсэн амжилтыг хүчингүйд тооцон, шагналыг дараагийн байрт шалгарсан тамирчинд шилжүүлэн олгоно.

\*\*\*\*

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын  
хамтарсан 2009 оны 53/45 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт

## **Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Сонирхогчдын спортын төрлөөр Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадам \цаашид “Тэмцээн” гэх\ зохион байгуулах, санхүүжүүлэх харилцааг холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд энэхүү журмаар зохицуулна.

1.2.Тэмцээн зохион байгуулах спортын холбоо нь сүүлийн 3-аас доошгүй жил тухайн спортын төрлөөр спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн байна.

### **2. Тэмцээнийг зохион байгуулах эрх авах:**

2.1. Спортын холбоо нь Монгол Улсад тэмцээн зохион байгуулах хүсэлтийг олон улсын холбоонд гаргахын өмнө Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэмжлэг, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдаас зөвшөөрөл авна.

2.2. Тэмцээн зохион байгуулах зөвшөөрөл авахдаа дараах материалыг бүрдүүлэн Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж тэмцээн зохион байгуулахад дэмжлэг хүссэн албан тоот;
- Тэмцээний танилцуулга;
- Тэмцээний төсвийн тооцоо;
- Тэмцээний бэлтгэл ажлын төлөвлөгөө.

2.3 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь спортын холбооны хүсэлт, тэмцээн зохион байгуулах боломжийг судлан Эрүүл мэндийн сайдад уламжилна.

2.4 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн материалыг хянан үзэж Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд урьдчилсан зөвшөөрлийг олгоно.

2.5 Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын урьдчилан олгосон болон эрх бүхий олон улсын спортын байгууллагаас ирүүлсэн албан ёсны зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу тэмцээн зохион байгуулах эрх нээгдэнэ.

2.6 Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийг тэмцээний өмнөх оны эхний улиралд багтаан гаргуулж, зардлыг улсын төсөвт суулгах асуудлыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

### **Гурав. Тэмцээнийг зохион байгуулах**

3.1 Тэмцээнийг Монгол Улсын Засгийн газраас батлагдсан Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагын удирдлага хяналтын дор тухайн спортын үндэсний холбоо Олон улсын холбоо, бусад оролцогч, дэмжигч /цаашид зохион байгуулагч гэх/ байгууллагуудтай хамтран батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явуулна.

3.2 Зохион байгуулах хорооноос тэмцээний заавар, хөтөлбөрийг олон улсын байгууллагын тэмцээний төлөвлөгөө, хуваарьт тусгуулна.

3.3 Зохион байгуулах хороо нь тэмцээн дууссанаас хойш ажлын 20 хоногт багтаан тэмцээний тайлан дүнг хэлэлцэн, Засгийн газарт хүргүүлнэ.

3.4. Зохион байгуулагч тэмцээнд оролцогчдийг хүлээн авах, байрлуулах, үдэх аюулгүй байдлыг хангах бусад үйлчилгээний асуудлыг хариуцана.

### **Дөрөв. Тэмцээнд бэлтгэх, оролцуулах**

4.1 Тэмцээнд оролцох Монголын баг тамирчдын бүрэлдэхүүн, удирдамжийг тэмцээний зэрэглэлээс хамаарч Засгийн газрын мөнгөн шагналд хамрагдах бол Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бусад тохиолдолд тухайн спортын үндэсний холбоо батална.

4.2 Тэмцээнд бэлтгэх, оролцох тамирчид, дасгалжуулагчдыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн үндсэн ажил, хичээлээс нь дор дурдсан хугацаагаар /ажлын хоног/ чөлөөлнө. Үүнд:

- Олон улс, тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход 40-өөс доошгүй хоног;
- Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход 60-аас доошгүй хоног;
- Олимпийн наадамд оролцоход 90-ээс доошгүй хоног;
- Шүүгчдийг тэмцээний өмнөх гурав болон тэмцээний өдрүүдэд.

4.3 Ажлаас чөлөөлөгдсөн хугацааны цалинг дараах байдлаар өмчийн хэлбэр харгалзахгүйгээр үндсэн байгууллагаас нь олгоно.

4.3.1. Хийснээр буюу цагаар цалин олгодог бол сүүлийн гурван сарын цалингийн дунджаар;

4.3.2 Тогтмол цалин олгодог бол чөлөөлөгдсөн хугацаанд ногдох хэсгийг.

4.4 Энэ журмын 4.2, 4.3 дэхь заалтууд нь гадаадад тэмцээнд оролцох тамирчин, дасгалжуулагчдад нэгэн адил хамаарна.

4.5 Тэмцээнд оролцсон баг тамирчдын удирдамжийн биелэлтийг тухайн баталсан байгууллага дүгнэнэ.

### **Тав. Тэмцээнийг санхүүжүүлэх**

5.1 Монгол Улсын Засгийн газраас олгосон хөрөнгийн зарцуулалтад Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг байгууллагын дансанд бүртгэн авна.

5.2 Засгийн газраас дор дурдсан зардлыг санхүүжүүлнэ. Үүнд:

5.2.1 Тэмцээний заал, талбай, узелийн хөлс;

5.2.2 Байгууллага, баг тамирчид, дасгалжуулагчдад олгох цом, медаль, өргөмжлөлийн зардал;

5.2.3 Тэмцээний шүүгчийн ажлын хөлс;

5.2.4 Эмнэлгийн яаралтай болон анхны тусламж үйлчилгээний зардал;

5.2.5 Дэлхийн сэргээшийн эсрэг агентлагийн дүрмийн дагуу тамирчдаас авах сэргээшийн хяналт, шинжилгээний зардал;

5.2.6 Тэмцээнд оролцох монголын баг тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтын байр, хоол, бэлтгэлийн хувцас, хэрэгслийн зардал;

5.2.7 Тэмцээн зохион байгуулахад шаардлагатай спортын хэрэглэл материалын зардал;

5.2.8 Олон улсын холбооны зохион байгуулагч, хянагчдын ажлын хөлс,

5.2.9 Мэдээлэл, сурталчилгааны хөлс

5.2.10 Тээвэрийн үйлчилгээний зардал

5.2.11 Нээлт, хаалтын арга хэмжээний зардал

5.3. Тэмцээн зохион байгуулахад шаардлагатай спортын хэрэглэл материалыг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналаар олгох ба төсвийн хөрөнгөөр өмнөх тэмцээнийг зохион байгуулахад авсан бол 5 жилийн дотор нэг байгууллага, холбоонд дахин олгохгүй.

5.4 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Олон улсын тэмцээнийг зохион байгуулахаар шинээр худалдан авсан техник хэрэгслийг өөрийн балансанд бүртгэн авч, дараагийн тэмцээн зохион байгуулахад ашиглана.

5.5 Энэ журмын 5.2-т зааснаас бусад зардлыг тухайн спортын холбоо болон ивээн тэтгэгч байгууллага хариуцна.

5.6. Тэмцээнд оролцогчдын замын зардал /ирэх, буцах/ Монголд байх байр, хоол, үзвэр, бусад төрлийн үйлчилгээний зардал, төлбөр хураамжийг тэмцээний зааварт тусган оролцогч талд хариуцуулна.

5.7. Тэмцээний нэр хүндийг өсгөх, оролцогчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төлбөр, хураамжинд хөнгөлөлт үзүүлж болно.